



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№66 /510/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.04.24

Цаг үе, үйл явдал

ЗХЖШ-ЫН ДАРГА БРИГАДЫН ГЕНЕРАЛ С.ГАНБЯМБА БАРУУН БҮСЭД АЖИЛЛАЛАА



ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямбаар ахлуулсан ажлын хэсэг Монгол орны баруун бүсэд үйл ажиллагаагаа явуулдаг Зэвсэгт хүчний 123, 341, 339 дүгээр ангид ажиллалаа.

Дээрх ангийн удирдлагууд ангийн үндсэн үүрэг, түүхэн замнал, дайчин уламжлал, өнөөгийн байдал, хийж хэрэгжүүлсэн бүтээлч ажлууд, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа, сүүлийн үеийн ололт амжилтуудын талаар дэлгэрэнгүй танилцуулсан юм.

ЗХЖШ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг хэд хэдэн чухал асуудлыг шийдвэрлэхээр хэлэлцэж цэргийн ангийн бүх объект, барилга байгууламж, шинээр ашиглалтад орсон орон сууц, Эрүүл мэндийн төв, цэргийн гал тогоо, номын сан, Соёл, спортын төв, тавиулан, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын амьдарч буй орчин нөхцөлтэй нэг бүрчлэн танилцсан юм. Энэ үеэр цэргийн алба, сахилга зохион байгуулалт, зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийн хангалтын байдалтай танилцан ойрын хугацаанд тодорхой зарим асуудлуудыг шийдвэрлэхийг үүрэгдлээ.

Үүний дараа нийт бие бүрэлдэхүүнтэй

уулзалт зохион байгуулж холбогдох үүрэг чиглэлийг өглөө. Уулзалтын эхэнд ЗХЖШ-ын шинэ бүтэц зохион байгуулалт, Төрлийн цэргийн командлалуудад гарч буй сургалтын тогтолцооны шинэчлэл болон Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа "Алсын хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлого, Цэргийн мэргэжлийн дээд байгууллагын оролцож байгаа "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөн, Эх орны стратегийн томоохон бүтээн байгуулалтад оролцож байгаа анги салбаруудын оролцоо, ололт амжилтуудын талаар тодотгосон юм.

Мөн ЦХХХЯ-аас санаачилсан "Цахим Монгол" хөтөлбөр Зэвсэгт хүчинд хэрхэн хэрэгжиж байгаа талаар мэдээлэл өгөв. Тодруулбал, Батлан хамгаалахын сайдын тушаалаар Энхийг сахиулах ажиллагаанд цэргийн алба хаагчдыг сонгон шалгаруулахдаа тусгай журам баталж түүгээр аппликейшн бүтээж буй талаар хэлсэн юм. Энэ ажил үр дүнд хүрснээр шударга бус тогтолцоог халж энхийг сахиулах ажиллагаанд оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхээ харах боломжтой гэлээ.

ЗХЖШ-ын дарга бригадын генерал

С.Ганбямба ангиудын нийт бие бүрэлдэхүүнд хандаж хэлсэн үгэндээ "ЗХЖШ-аас 2023 оныг "Залуу офицеруудын манлайлын жил" болгосон зарласантай холбогдуулан цэргийн алба хаагч бүр идэвх санаачилгатай, зарчимч, хичээнгүй, анги, салбартаа ажил үйлс, амжилт бүтээлээрээ манлайлж, салбартаа тэргүүлэгч нь байх ёстой" хэмээн уриалсан юм. Түүнчлэн цаг ямагт өөрийгөө дайчлан хөгжил дэвшлийн шинэ зуунтай хөл нийлүүлэн алхаж, тасралтгүй хөгжин албандаа хандах хандлага, сахилга хариуцлагаа дээшлүүлэхийг үүрэг болгов.

ЗХЖШ-ын даргыг дагалдан Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал болон ЗХЖШ-ын АУГ-ын Цэргийн албаны хэлтсийн ахлах мэргэжилтэн хурандаа Ц.Бат-Орших, МТГ-ын Техникийн хэлтсийн дарга хурандаа Б.Энхболд, Материал хангалтын хэлтсийн Материал хэрэгслийн хангалтын төлөвлөлт, зохицуулалтын ахлах мэргэжилтэн хурандаа Ө.Тамир нар ажилласан юм.

Дэслэгч Б.ЭРДЭНЭБАТ

БНСВУ-ЫН БХЯ-НЫ ЦЭРГИЙН АЖ ҮЙЛДВЭРИЙН КОРПОРАЦЫН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗАЛТ ХИЙВ



БНСВУ-ын БХЯ-ны Цэргийн аж үйлдвэрийн корпорацийн ерөнхий менежер, хурандаа Нгуен Ву Ха тэргүүтэй төлөөлөгчид 2023 оны 04 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд манай улсад айлчилж байна.

БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг төлөөлөгчдийг хүлээн авч уулзах үеэр Батлан хамгаалах яамны удирдлагын зүгээс хоёр

орны батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг дэмжиж байгаа, тэр дундаа эдийн засгийн хөгжил, техник, технологийн дэвшлээрээ бус нутагтаа тэргүүлж байгаа Вьетнам улстай цэргийн аж үйлдвэрийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх сонирхолтой байгаагаа онцлон тэмдэглэв.

Энэхүү айлчлал нь Монгол Улсын Засгийн газрын

гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын өнгөрсөн оны 12 дугаар сард БНСВУ-д хийсэн албан ёсны айлчлалын дараагаар болж байгаа бөгөөд хоёр орны цэргийн аж үйлдвэрийн харилцааг хөгжүүлэх чиглэлээр хийж буй айлчлал юм. Хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа 2013 онд

байгуулсан санамж бичиг, 2019 онд байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх, туршлага, сургамжаа хуваалцах, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр идэвхжиж байгаад баяртай байгаагаа талууд харилцан илэрхийлсэн юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 4	☁️ -5

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	☁️ 28

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,485	3,492
EUR 🇪🇺	3,835	3,855
CNY 🇨🇳	507	509.80
RUB 🇷🇺	42,30	42.80
JPY 🇯🇵	25.90	26.20
KRW 🇰🇷	2.64	2.67

ЗУРХАЙ



2023.04.24 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 4

ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ САР
НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАР ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:
Бие эрхтний хүч сайжирна
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.54-19.48
Барилдлага:
Үл зохилдох
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Сэрэхүй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 686,579,938

Эдгэрсэн

Нийт: 658,153,325

Нас барсан

Нийт: 6,760,231

Цахим шууданд

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН АЛБАНААС ҮЗЛЭГ, ОНОШЛОГОО ЯВУУЛЛАА



нэгж техникүүдэд үзэгдэлтийг сайжруулах зорилгоор гэрэл ойлгох шинж чанар бүхий туузан наалтыг шинэчлэн наалгалаа. Мөн ЦЕГ-ын Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтсийн чиглэлийн ахлах мэргэжилтэн цагдаагийн хошууч Э.Энхболд “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” сэдвээр сургалт явуулсан бөгөөд төгсгөлд нь “Замын хөдөлгөөний дүрэм”-ээр шалгалт авсан юм.

Цаашид тус албанаас жил бүрийн тээврийн хэрэгслийн тооллого, техникийн хяналтын улсын үзлэгийг явуулахдаа Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын тээврийн хэрэгслүүдийг явуулын болон суурин оношилгооны төхөөрөмжөөр үзлэг оношилгоонд хамруулж, дүгнэлт гаргаж ажиллахаар төлөвлөөд байна.

Улаанбаатар, Налайх, Зуун мод цэргийн хүрээний Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын хүн тээврийн автобусуудад үзлэг оношлогоо хийлээ.

Тодруулбал, Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, “Тээврийн хэрэгслийг ашиглахад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндсэн шаардлага”, “Тээврийн хэрэгсэлд техникийн үйлчилгээ, засвар хийхэд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндсэн шаардлага”, “Тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглох, эвдрэл, гэмтэл, техникийн зөрчлийн жагсаалт”-д заагдсан зөрчлүүдийг арилгуулах, “Авто тээврийн хэрэгсэлд тавигдах MNS 4598:2020” ерөнхий стандартыг хангуулах зорилгоор дээрх үзлэг оношлогоог явуулсан юм.

Үзлэгийн явцад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилго бүхий цацруулагч наалтгүй байсан



ЦЭРГИЙН АЛБА ХААНГАА МЭРГЭЖИЛ ЭЗЭМШИЖ, ЖОЛООНЫ ДАМЖААНД СУРАЛЦАЖ БАЙНА



БНМАУ-ын баатар хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн 50 жилийн ой энэ онд тохиож байгаа билээ.

Түүхт ойн хүрээнд болон сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу хугацаа цэргийн алба хаагчдынхаа хувь хүний хөгжлийг дэмжих, мэргэжил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх, жолооны дамжаанд суралцуулах зэрэг бүтээлч ажлуудыг өрнүүлж байна.

Энэхүү сургалт, дамжаанд хугацаат цэргийн алба хаагчдаас

Тухайлбал, Өмнөговь аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран цэргийн тэтгэвэрт гарсныхаа дараа ажиллаж амьдрахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ахлах ахлагч Э.Бат-Эрдэнэ, Э.Бямбадэлгэр болоод 50 орчим хугацаат цэргийн алба хаагчийг “Үйлдвэрлэлийн механик”, “Барилгын бетон, арматурчин”, “Цахилгаанчин”, “Үйлдвэрийн механик” гэсэн мэргэжлээр суралцуулж байна.

Энэхүү сургалт нь Өмнөговь аймгийн ЗДТГ, “Оюутолгой” компанийн хамтын

халагдаад уул уурхай, барилга инженерийн салбарт шууд ажиллах боломжтой болж байгаа юм.

Мөн Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн Техникийн бага мэргэжилтэн бэлтгэх сургалтын төв, Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба, Цагдаагийн



Ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвүүдтэй хамтран ангийн зарим офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдад “В, С” ангиллын жолооны дамжааг зохион байгуулж байна. Сургалтыг хөдөлгөөнт бүлгийн багш, хошууч Б.Батдэлгэр, сургагч ахлагч Б.Эрдэнэчулуун, ахлах ахлагч Д.Гансүх болон Т.Хүрэлбаатар нар удирдан явуулж байна.

Жолооны дамжаанд хугацаат цэргийн алба хаагчдаас гадна ангийн дэд ахлагч Д.Түвдэндорж, Б.Галавсамбуу нар хамрагдсан нь алба хаагчдынхаа ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэхийн зэрэгцээ “Залуу офицер ахлагчийн манлайллын жил”-тэй уялдуулж байгаа юм.

Хошууч Ц.ГАНБАЯР



гадна тэтгэвэр чөлөөнд гарах алба хаагчдыг хамруулж, нийгэмд эрэлттэй мэргэжлээр давхар сургаж байгаа юм.

ажиллагааны “Говийн хөгжлийг дэмжих сан”-гийн хөрөнгө оруулалтаар явагдаж байгаа бөгөөд хугацаат албаны дайчид

НАЛАЙХ ДҮҮРГИЙН “ДӨЛ” ТЭМЦЭЭНИЙ ШИЛДГҮҮД ТОДРОВ



Монгол Улсад Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан Налайх дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын “Дөл-2023” тэмцээний шилдгүүд тодорлоо.

Тэмцээнд Налайх дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, Политехник коллежийн 6 баг оролцож хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс нийлбэр дүнгээр гутгаар байрт Н.Төгөлдөр ахлагчтай 103 дугаар сургуулийн нэгдүгээр баг, дэд байрт С.Хүслэн ахлагчтай Налайх

Политехник коллежийн баг, тэргүүн байрт Л.Мөнхсайхан ахлагчтай 109-р сургуулийн баг тус тус шалгарч үеийн олон нөхдөө манлайллаа.

Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээн нь хүүхэд залуучуудад эх орон, тусгаар тогтнол, эрх, эрх чөлөөний үнэ цэнийг ойлгуулах, цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх, бие бялдрын болон сэтгэл зүйн хүмүүжлийг олгох, эх орноо батлан хамгаалах бэлтгэлийг эзэмшүүлэх чухал ач холбогдолтой билээ.

Ахлагч Б.НОМИН-ЭРДЭНЭ



“ГЭР БҮЛ БОЛ НИЙГМИЙН ИРЭЭДҮЙ” СЭДЭВТ ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



сургууль ТББ-ын захирал Б.Бат-Оргил “Гэр бүлийн боловсрол”, Эрчүүд гэр бүл, хүүхэд хөгжлийн нийгэмлэгийн тэргүүн Д.Эрдэнэцогт “Нийгэм дэх эрчүүдийн байр суурь ба жендерийн харилцаа”, БЗД-ийн Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн хошууч Г.Баяр-Эрдэнэ, хошууч А.Дэлгэрцэцэг нар “Цахим гэмт хэрэг мөрийтэй тоглоом”, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга зам” сэдвээр тус тус яриа таниулга хийж нийт бие бүрэлдэхүүнд шаардлагатай мэдээ мэдээлэл, тусламж, зөвлөгөөг өгч ажиллаа.

Ангийн нийт бие бүрэлдэхүүнд тулгамдаж буй нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний 124 анги “Гэр бүл бол нийгмийн ирээдүй” сэдэвт өдөрлөгийг зохион байгууллаа.

Ажилтан алба хаагчдад бодит дэмжлэг, туслалцаа болж чадсан үр дүнтэй сургалт зохион байгуулах үүднээс энэ удаагийн сургалтыг Баянзүрх дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтэс, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрчүүд гэр бүл, хүүхэд хөгжлийн нийгэмлэг, Зэвсэгт хүчний 084 дүгээр ангитай хамтран явуулсан юм.

Өдөрлөгөөр СЭМҮТ-ийн ахлах мэргэжилтэн О.Батчимэг “Стресс ба түүнээс гарах арга зам”, Гэр бүлийн

